



ХЭНТИЙ АЙМАГ  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/26

Өмнөдэлгэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.516.5.5 , дахь хэсэг, Эрүүл мэндийн сайд, монгол улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, боловсрол шинжлэх ухааны сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2024 оны А/75, А/09, А/73, А 34 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхдийн сувилал ажиллуулах удирдамжийг нэгдүгээрт, шаардагдах зардалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулагдах 1754200 (нэг сая долоон зуун тавин дөрөв хоёр зуу) төгрөгийг нийгмийн эрүүл мэндийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Б.Сэр-Од)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Э.Ган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.АРИУНТУНГАЛАГ